



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН СУДАЛГАА, 2021-2022



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ЭСРЭГ
ДЭЛХИЙН ӨДӨР


2023 ОНЫ 6 САРЫН 12





ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ ТООЦОХ ХЭМЖИЛТИЙН ХҮРЭЭ

Монгол Улс хүүхдийн хөдөлмөртэй холбоотой үндсэн конвенцуудыг соёрхон баталж, хөдөлмөрийн насны доод хязгаарыг 15 нас байхаар тогтоосон. Мөн Монгол Улс 13-14 насны хүүхдийг хөнгөн ажил эрхлэхийг зөвшөөрч, хүүхдэд аюултай ажлын жагсаалтыг баталсан.





ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Аливаа эдийн засгийн үйл ажиллагаа нь хүүхдийн хөдөлмөр мөн эсэх нь хүүхдийн нас, ажлын цаг, нөхцөл, гүйцэтгэж буй ажлын төрлөөс хамаарна. Хэрвээ хүүхэд бага наснаасаа, урт цагаар эсвэл бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, хөгжил, боловсорч сурахад нь нөлөөлөхүйц ажил эрхэлдэг бол энэ нь хүүхдийн хөдөлмөр болно.



Монгол Улсад **138 мянга гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлж** байна.



37.4%
Охид



62.6%
Хөвгүүд




5-17 насны хүүхдийн **16.2%**



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөр эрхэлж буй 5 хүүхэд тутмын 3 нь 5-12 насны хүүхэд, мөн 5 хүүхэд тутмын 2 нь аюултай ажил эрхэлж байна.




■ Хүүхдийн аюултай ажил

■ Хөнгөн ажил хийж болохуйц наснаас доош нас (5-12 нас)-ны хүүхдийн ажил

■ 13-14 насны хүүхдийн аюулгүй ч хөнгөн бус ажил

Хүүхдүүд ихэвчлэн **ус зөөх, түлээ, мод бэлтгэх үйл ажиллагаанд болон хөдөө аж ахуйн салбарт** хөдөлмөр эрхэлж байна.



■ Хөдөө аж ахуйн салбар


■ Аж үйлдвэр, барилгын салбар

■ Үйлчилгээний салбар

■ Ус зөөх, түлээ, мод бэлтгэх үйл ажиллагаа

■ Цалин хөлсгүй дагалдан ажил эсвэл гэрийн ажил

Бүх насны бүлэгт охидтой харьцуулахад хөвгүүд ихээр хүүхдийн хөдөлмөр эрхэлж байна.




■ Охид

■ Хөвгүүд

■ Бүгд

Хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн ихэнх нь **хөдөө амьдарч** байна.





АЮУЛТАЙ АЖИЛ

Хүүхдийн аюултай ажил гэж хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аюултай шинж чанар бүхий (аюултай орчин, тоног төхөөрөмж, салбар, ажил мэргэжил) аливаа ажил, үйл ажиллагаа юм.

Хөвгүүд охидыг бодвол аюултай ажилд илүү их оролцож байна.



31.7%


Охид



68.3%

Хөвгүүд


Ажил эрхэлж буй хүүхдүүдийн ихэнх нь том мал, тэжээвэр амьтадтай харьцаж эсвэл өтөг, бууц, ялгадастай орчинд ажиллаж байсан тул аюултай ажил эрхлэлтэд тооцогдсон.




- Зөвхөн салбар, мэргэжлийн хувьд аюултай ажил
- Зөвхөн хэт их цагаар ажиллах (40 ба түүнээс дээш цаг)
- Зөвхөн хөдөлмөрийн аюултай нөхцөл
- Бусад/холимог



Аюултай ажил эрхэлж буй хүүхдийн ихэнх нь **хөдөө** амьдарч байна.



Аюултай ажил эрхэлж буй 10 хүүхэд тутмын 7 нь ажил, мэргэжлийн хувьд аюултайд тооцогдож, эдгээр хүүхдийн 1.2 мянга (29.1%) нь эмнэг сургах эсвэл хурдны морь унах, хурдны морь уяхад тулсах үйл ажиллагаанд оролцжээ.



- Ачаа өргөж зөөх, буулгах ажил
- Эмнэг сургах, хурдны морь унах
- Барилгачин
- Шууун аж ахуйн ажилтан
- Барилга угсрах үйлдвэрт зуурмаг бэлтгэх, үйлдвэрлэлийн бус орчинд цемент задгайгаар савлах ажил
- Өөрийн төрсөн гэр болон төрсөн ах, эгч, эмээ, өвөөгөөс бусад айлд амьдарч, мал маллах
- Газар тариалангийн механикжсан ажил
- Бусад ажил мэргэжил



ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа гэж бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх аливаа үйл ажиллагааг тухайн хугацаанд нэг цагаас доошгүй эрхэлсэн 5-17 насны хүүхдийн үйл ажиллагаа юм.



39.3%

Охид



60.7%

Хөвгүүд


Хөвгүүд охидыг бодвол эдийн засгийн үйл ажиллагаанд ихээр оролцох хандлагатай байна.

5-17 насны хүүхдүүдийн **24.4%** нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна.



Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй **3 хүүхэд тутмын 2 нь** зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




- Зөвхөн цалин хөлс, ашиг олох зорилготой ажил эрхэлдэг хүүхэд
- Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н үйлдвэрлэлийн ажил эрхэлдэг хүүхэд
- Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээний ХАА-н бус үйлдвэрлэлийн ажил эрхэлдэг хүүхэд
- Цалин хөлс, ашиг олох зорилготой ажил болон өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажлыг хамт эрхэлдэг хүүхэд
- Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл эрхэлдэг хүүхэд (ХАА-н болон ХАА-н бус хамт)
- Бусад хэлбэр




ХАРЬЦУУЛАЛТ


Хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оролцуулах нь **хүүхдийн боловсролд сөргөөр нөлөөлдөг**.



Ажлын бүх хэлбэрүүдэд **5-12 насны хүүхэд** ихэнх нь байна.



ТХЗ-ын үзүүлэлт 8.7.1 Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн эзлэх хувь буюу 5-17 насны хүүхдэд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эзлэх хувь 2012 онд 7.4% байсан бол **сүүлийн 10 жилд нэмэгдэж**, 2022 онд 16.2% болжээ.



* Арга зүй, хэмжилтийн тогтолцоонд өөрчлөлт орсон тул чиг хандлагыг тайлбарлахдаа анхаарах хэрэгтэй.



Үндэсний Статистикийн Хороо
Засгийн газрын III байр, Бага тойруу - 44,
Улаанбаатар - 11, Монгол Улс



976-70141212



information@nso.mn



www.1212.mn

Энэхүү судалгааг ОУХБ болон АНУ-ын Хөдөлмөрийн яамны
санхүүжилтийн хүрээнд IL-30147-16-75-K-11 (MAP16 төсөл)
дугаартай хамтын ажиллагааны гэрээний дагуу зохион байгуулав.